

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол улсад шударга ёс, хариуцлага, хөгжил цэцэглэлийг төлөвшүүлэхийн төлөөх хамтрагч

## НИЙТ МОНГОЛЧУУДЫН ТУСЫН ТУЛД ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ ЗӨВШӨӨРЧ ДЭМЖСЭН 51 ОРОЛЦОГЧ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

Төрийн, хувийн болон төрийн бус хэвшлийг төлөөлсөн 51 оролцогч энэ оны 4-р сарын 4-ний өдөр Олон талт оролцогчдын уулзалтанд хурал цуглаж Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолт, түүний үндсэн найман зарчмыг дэмжихээр илэрхийлэв. Дурдсан тодорхойлолт хийгээд зарчмууд нь үндэсний хэмжээний зорилтуудыг хэрэгжүүлэх үйл явцад төрөл бүрийн ашиг сонирхол бүхий хэсэг бүлгүүдийг хамран оролцуулах ирээдүйн харилцан уялдаат хамтач ажиллагааны үндэс суурийг бүрдүүлэх болно. Тодорхойлолт, зарчмуудыг боловсруулан бэлтгэх үйл явцыг олон талт оролцогчдын уулзалтуудын түрүүчээр 2006 оны эцэст болсон төрийн, хувийн болон төрийн бус хэвшлийнхэн оролцсон ажлын хэсгийн хуралдаанаас эхлэсэн билээ.

Олон талт оролцогчдын энэхүү үйл явцыг түүнийг эрхлэн явуулж тэмдэглэлийг нь хөтөлсөн Азийн сан зохион байгуулсан. Анхны хуралдаанд оролцсон 90 орчим оролцогч хариуцлагатай уул уурхайн тодорхойлолтыг боловсруулахад хамтран ажиллахаар тогтсон. Удаах буюу 12-р сарын эхээр хуралдсан хоёрдахь удаагийн хуралдаанаар Ажлын хэсгийг эмхлэн бүрдүүлж, Цагаан сар гэхэд тодорхойлолтын төслийг бэлэн болгохоор зорьж ажлаа эхлэсэн. Ингээд 2-р сарын 2-нд тодорхойлолт болон зарчмуудыг бүрэн бүрэлдэхүүнээр хэлэлцээд 20 гаруй байгууллага зөвшөөрч гарын үсэг зурсан. Улмаар 4-р сарын 4-нд нэмж 20 гаруй байгууллага зөвшөөрч буйгаа мэдэгдэн нэрсээ өгсөн.



Олон талт оролцогчдын хуралдаанд оролцогчид Хариуцлагатай уул уурхайн төвийг үүсгэн байгуулах Ажлын хэсгийг эмхлэн бүрдүүлэх саналыг дэмжин гараа өргөж байгаа нь

Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Ерөнхийлөгч ноён Д.Ганболд “Нэгдмэл ойлголцлын ерөнхий хүрээтэй болсон маань цаашдын харилцан уялдаа, хамтын ажиллагаанд хамгаас чухал” гэдгийг цохон тэмдэглэсэн.

Хариуцлагатай уул уурхай нь оролцогчдын хамтын ажиллагаа, сайн засаглал, үндэсний эрх ашигт үйлчлэх бусад зарчимд суурилах болно. Үндэсний эрх ашиг гэдэгт Монголд удаа дараа явагдсан олон нийтийн санал асуулгуудаар хамгийн тулгамдсан чухал асуудлууд хэмээгдсэн эдийн засгийг хөгжүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох зорилт багтана. Олон талт оролцогчдын хуралдаануудыг даргалсан Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Бакей “Төрийн, хувийн болон төрийн бус хэвшлүүд нийт монголчуудын ашиг тусын төлөө тодорхой үр дүнд хүргэх нийтлэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж чадна гэдгийг энэхүү үйл явц илтгэн харууллаа” хэмээн өндөр үнэлсэн юм.

### Хариуцлагатай уул уурхайн тодорхойлолтын төсөл

Бүх оролцогч талуудын, ялангуяа нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэсэн, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, олон улсын шилдэг туршлагад тулгуурлаж, хууль сахиу ёсыг дээдэлсэн, Монгол Улсад байнгын ашиг орлого оруулж байх эрдэс баялгийн салбар дахь ил тод, цогц үйл ажиллагааг хариуцлагатай уул уурхай гэнэ.

#### Зарчмууд:

- Олон талын оролцоог хангах,
- Ил тод нээлттэй байх,
- Хуулийг сахиу дээдлэх,
- Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх,
- Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах,
- Үр өгөөжтэй байх,
- Хүмүүнлэг ёс зүйтэй байх,
- Дэвшилт технологид суурилсан байх.

### МОНГОЛ УЛС

Азийн сан нийт монголчуудын тусын тулд байгалийн баялагийг хариуцлагатай ашиглах явдлыг хөхиүлэн дэмжих зорилгын үүднээс төрийн, хувийн болон төрийн бус хэвшилтэй хамтран ажилладаг.

Өвлийн улиралд хаагддаг Гутайн уурхайн харуул иргэдэд, энэ уурхайд зуны саруудад 30-40 ажилчин ирж ажилладаг боловч тэдний дотор нутгийнхнаас ганц ч хүн байдаггүй. Тэд бүгд Улаанбаатар хотоос болон бусад газраас түр хугацаагаар хүрч ирээд буцдаг болохоор орон нутагт шууд ногддог эдийн засгийн үр ашиг байхгүй, байсан ч тун бага гэж яриу.

04/07

Дөрөвдэх удаагийн хуралдаанд оролцогчид нийтийн зөвшилцлийн үр дүнд бий болсон тодорхойлолтыг сайшаан гарын үсэг зурсанаас гадна оролцогчдын дагаж мөрдөх учир Тунхаглал буюу ойлголцлын санамж бичгийн төслийг бичиж боловсруулах ажлын хэсгийг эмхлэн бүрдүүлж, Хариуцлагатай уул уурхайн төвийг үүсгэн байгуулах гарааг эхлүүлсэн. Оролцогчид тус төвөөс эрхлэн явуулж болох өргөн хүрээтэй зарим нэг ажиллагааны талаар зөвлөн ярилцсаны дотор мэдээ мэдээлэл, мэдлэг түгээх, бодлогын асуудлаар зөвлөгөө өгөх, сурталчилгаа таниулга хийх, техникийн зөвлөгөө өгөх, Хариуцлагатай уул уурхайн тэргүүлэх найман зарчмын хэрэгжилтийг хөхиүлэн дэмжихэд хошуучлан оролцох боломжтой гэж үзсэн.

Хариуцлагатай уул уурхайн төвийг үүсгэн байгуулахаар 14 гишүүнтэй Ажлын хэсгийг эмхлэн бүрдүүлсэн бөгөөд гишүүдийн нэрсийг дор жагсаав. Үүнд:

А Бакей	УИХ-ын гишүүн
З.Энхболд	УИХ-ын гишүүн
Ц.Дамиран	УИХ-ын гишүүн
С.Ганбаатар	Соёмбо хөдөлгөөн
Г.Уранцоож	Хүний эрх, хөгжил төв
Д.Сүхбаатар	Инкубатор төв
Б.Баярмаа	Монгол Нутаг Мину Эвсэл
Д.Ганболд	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци
Д.Чинзориг	Уул уурхайн салбарын залуучуудын холбоо
Г.Батсайхан	Байгаль орчны яам
З.Батбаяр	Монголын Усны хэрэг эрхлэх газар
Л.Долгормаа	Дэлхийн байгаль хамгаалах сан
Б.Арвинбаяр	Монголын Шинжлэх ухаан, технологийн Их сургууль
Д.Хэрлэн	Азийн сан /Нарийн бичгийн дарга/

Энэхүү ярилцлагын явцад Олон талт оролцогчдын бүлгийн хүсэлтээр Азийн сангаас явуулсан суурь судалгааны дүнг мэдээлэв /Азийн санд хүсэлт тавиад авч болно/.

Уулзалтыг угтсан хэлэлцүүлгийн хүрээнд хэд хэдэн баримт бичгийг тараасны дотор ижил төстэй нэгэн төвүүд байгуулагдсан Бритиш Колумби, Квинсайландын жишээг авч үзсэн, Хариуцлагатай уул уурхайн жишиг стандартыг бий болгохоор хийгдэж буй ажлуудын талаар дурдсан байлаа. (Дор дурдсан мэдээллийг үзэхээс гадна <http://www.responsiblemining.net/> вэб хуудсанд зочилно уу).

### Хариуцлагатай уул уурхайн баталгаа бий болгох санаачилга /ХУУББС/

ХУУББС бол уул уурхайн салбарын үйл ажиллагаанд байгаль орчин, хүний эрх, нийгмийн жишиг стандартуудын хэрэгжилтийн байдлыг бие даан шалгах сайн дурын тогтолцоог боловсруулж бий болгох зорилгоор Канад улсын Ванкувер хотноо 2006 оны 6 дугаар сард гараагаа эхлэсэн салбар дундын хүчин чармайлт болой. Эдүгээ нэгэнт бий болсон судалгаа, тоног төхөөрөмж болон Хариуцлагатай уул уурхайн хүрээндээ эхлээд Тогтвортой хөгжлийн хүрээ, Эрдэс баялагийн уурхайн ба тогтвортой хөгжил төсөл, Уурхайн гэрчилгээгүүрлэлтийн үнэлгээ төслийг хүртэлх санал санаачилгуудад тулгуурлахыг ХУУББС эрмэлзэнэ.

ХУУББС уул уурхайнууд хариуцлагатай ажиллаж байгаа эсэхийг батлах хөндлөнгийн бөгөөд бие даасан тогтолцоог бий болгохыг зорих бөгөөд бүх хэвшлийн оролцоо, дэмжлэгтэйгээр ийнхүү ажиллаж байгаа болно. Чингэхдээ дараахийг үндэс болгоно. Үүнд:

- Бие даасан шалгалт хийх,
- Оролцогч талуудад үр ашгийг шударга агаад жигд хуваарилах,
- Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүйн болон соёлын үр дагаварт үр дүнтэй хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
- Оролцогчдын үнэлэмжийг дээшлүүлэх,

Доорхи байгууллагууд ХУУББС-д гишүүн болой.

#### **Уул уурхайн компаниуд**

AngloGold-Ashanti, BHP-Billiton, DeBeers Group, Falconbridge, Newmont, Rio Tinto, Xstrata

#### **Төрийн бус байгууллагууд**

Canadian Boreal Initiative, Center for Science in Public Participation, Conservation International, EARTHWORKS, Great Basin Minewatch, Oxfam America, Pembina Institute, Renewable Resources Coalition, World Wildlife Fund

#### **Жижиглэн борлуулагчид**

Tiffany & Co., Wal-Mart/Sam's Club

#### **Холбоод**

Council for Responsible Jewellery Practices, International Copper Association, International Council of Mining and Metals, Jewelers of America, the Nickel Institute

Азийн сан Олон талт оролцогчдын үйл явцыг болон томхон асуудлуудыг шийдвэрлэхээр байгуулагдаж буй ажлын хэсгүүдийг цаашид үргэлжлүүлэн дэмжих болно. Монголын Худалдаа Аж үйлдвэрийн танхимын ажилтан ноён Батнасангийн дүгнэж хэлсэнээр “Нийт монголчуудын тусын тулд ашигт малтмалын хариуцлагатай менежментийг хөгжүүлэх ‘адармаатай боловч үр өгөөжтэй’ энэхүү үйл явцад бид хамтран дэмжиж туслаж байгаа билээ”.